

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС  
2020 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРАЛД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 04 дүгээр сарын 06

Улаанбаатар хот


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2020 оны нэгдүгээр улиралд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 4726 ширхгийг шинээр хэвлэн, 2358 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 260 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийн, гадаадын 12 иргэнд регистрийн дугаар олгосон байна. Үйлчилгээний танхимаар 5342 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ.

Нийт 8227 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 4632, 7585-1882 дугаарын утсаар 149, 7013-3459 дугаарын утсаар 52, биечлэн 818, автомат хариулагчаар 2576 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Тайваний төлөөлөгчийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Бусан хот дахь консулын газрын ажилтанд утсаар, найман улсын гадаадын 37 иргэнд цахим шуудангаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.



2020 оны нэгдүгээр улирлын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувийн урилга олголт 28.3 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 0.4 хувиар, визийн сунгалт 9.8 хувиар тус тус өссөн, харин визийн зөвшөөрөл олголт 60.8 хувиар, виз олголт 29.7 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 29.9 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 8.0 хувиар, түр ирэгчийн бүртгэл 28.1 хувиар, түр ирэгчийн хасалт 10.2 хувиар тус тус буурсан байна.

Цахим визийн зөвшөөрлийн хүрээнд олон улсын хилийн боомт дээр “J” ангиллын 22, “S” ангиллын 200, “A” ангиллын 54, “O” ангиллын 31, “B” ангиллын нэг болон хоёр удаагийн орох 61, “B” ангиллын олон удаагийн гарах-орох 199 визийн зөвшөөрөл олгож, нийт давхардсан тоогоор 388 аж ахуйн нэгж, байгууллагын 741 хүсэлтийг хүлээн авч хянан, 358 аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын 567 иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан цахимаар шийдвэрлэжээ.

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын хоёр мэргэжилтэн ажиллаж 186 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, гадаадын 135 иргэнд визийн зөвшөөрөл, 147 иргэнд оршин суух зөвшөөрөл олгож, 364 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 45 иргэний ангиллыг сольж, 69 иргэнд хасалт хийсэн байна. Мөн хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй гадаадын 360 иргэнд зохих ангиллын виз олголоо.

Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан 03 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хөдөлмөр эрхлэгч, хөрөнгө оруулагч гадаадын иргэдийн Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн сунгалтыг цахимаар авч эхэлсэн бөгөөд тайлангийн хугацаанд “Т” ангиллын таван аж ахуйн нэгж, байгууллагын найман гадаадын иргэн, “НГ” ангиллын 14 аж ахуйн нэгж, байгууллагын 26 гадаадын иргэн, нийт 19 аж ахуйн нэгж, байгууллагын 34 гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгасан.

Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай Засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэртэй холбогдуулан Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олголт, Монгол Улсад түр ирэгч болон албан, хувийн хэргээр оршин суух гадаадын иргэний тус байгууллагаас авах үйлчилгээний тоо буурсан үзүүлэлттэй.

Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:


Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэг удаагийн зарлигаар харьяалалгүй нэг хүн Монгол Улсын харьяат болсон бол долоон удаагийн зарлигаар 138 иргэн гадаадын есөн улсын харьяат болохоор Монгол Улсын харьяатаас гарсан байна. Дээрх иргэдийн мэдээлэл болон Ерөнхийлөгчийн зарлигийг Гадаад харилцааны яамны Консулын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яаманд хүргэх ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан нэг улсын дөрвөн иргэний хүсэлтийг хүлээн авсан ба хуульд заасан шалгуурыг хангаагүй нэг иргэний хүсэлтийг буцаасан.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын долоон улсын харьяат болох хүсэлт гаргасан 78 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, гадаадын долоон улсын харьяат болох хүсэлт гаргасан 71 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийж байна. Мөн гадаадын зургаан улсын харьяат болох хүсэлт гаргасан 79 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, зургаан улсын харьяат болох хүсэлт гаргасан 89 иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлэв.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй зургаан хүний хүсэлтийг шинээр хүлээн авч, холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийж байна. Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй есөн хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, харьяалалгүй гурван хүний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлээ.

Мөн хоёрдмол харьяалал үүсгэсэн 54 иргэнийг шинээр бүртгэж мэдээллийн санд оруулсан ба 2020 оны нэгдүгээр улирлын байдлаар тус байгууллагын мэдээллийн санд хоёрдмол харьяалал үүсгэсэн 3583 иргэн бүртгэлтэй байна.



Тайлангийн хугацаанд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан 22 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан. Мэргэжлийн зөвлөлийн хоёр удаагийн хурлаар олон улсын болон гадаад улсын найман төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын асуудлыг хэлэлцэн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунган ажиллалаа.

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн 50 газрын 2019 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хүлээн авсан.

2020 оны нэгдүгээр улирлын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 89 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байна.

Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан гадаад улсын нэг гэр бүлтэй байгууллагын даргын 2010 оны А/395 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх журам”-ын дагуу ярилцлага хийн, Мэргэжлийн зөвлөлийн хурлаар

хэлэлцүүлснээр Монгол Улсын харьяат нэг хүүхдийг үрчлүүлж, үрчлэгч эцэг, эхтэй үрчлэлтийн дараах хяналт тавих хоёр талт гэрээг байгуулсан.

Мөн гадаадын хоёр улсын зургаан гэр бүлд үрчлүүлсэн гурван хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд баяжилт хийлээ.

#### 1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:


Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 13 улсын 110 иргэнийг байгууллагын даргын 35 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын 13 удаагийн тушаалаар гадаадын таван улсын 26 иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, 10 удаагийн тушаалаар гадаадын гурван улсын 16 иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.

Мөн байгууллагын даргын хоёр удаагийн тушаалаар гадаадын таван улсын 13 иргэний Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг сунгаж, нэг удаагийн тушаалаар гадаадын нэг иргэний Монгол Улсын хилээр нэвтрэх эрхийг хугацаанаас нь өмнө сэргээсэн.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр гурван улсын дөрвөн иргэнд гарах сануулга өгч, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн долоон удаагийн захирамжаар гадаадын дөрвөн улсын долоон иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн байранд саатуулж, нэг удаагийн захирамжаар нэг иргэний саатуулах хугацааг сунгав.

Тайлангийн хугацаанд долоон удаагийн төлөвлөгөөт, 21 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 298 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 391 иргэнийг хамруулсан. Түүнчлэн гадаадын 320 иргэн, 403 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 685 иргэн/, 11 уригч иргэн /гадаадын 11 иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 291,550,000 /хоёр зуун ерэн нэгэн сая таван зуун тавин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.



2020 оны нэгдүгээр улирлын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 3.9 хувиар, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 8.6 хувиар, зөрчил гаргасан уригч иргэн 22.2 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 29.4 хувиар, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 3.7 дахин тус тус өссөн байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тайлан, төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажил, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолын тус байгууллагад холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснээр Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжилтийг хурлын тэмдэглэлийн хамт, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тус байгууллагад холбогдох арга хэмжээний 2019 оны хэрэгжилт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу тус байгууллагад холбогдох хэсгийн тайлан, Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тус байгууллагад холбогдох арга хэмжээний хэрэгжилт, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, 2019 онд хүний нөөцийн чиглэлээр хийсэн ажлын тайлан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа хууль сахиулах байгууллагуудын жендерийн нэгдсэн бодлогын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөний биелэлт, 2020 оны төлөвлөгөө, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд албан бичгээр тус тус хүргүүлэн ажиллалаа.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэнтэй холбоотойгоор тус байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хоёр удаа албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, “Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний улирлын биелэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яам болон Гадаад харилцааны яаманд албан бичгээр тус тус хүргүүлэв.

Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн ажилласан. Мөн байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт болох байгууллагын 2020 оны сургалтын төлөвлөгөө, албан хаагчдын нийгмийн баталга хангах хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний саналыг зохион байгуулалтын нэгжүүдээс авч нэгтгэн, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр байгууллагын дарга баталж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүлсэн ба 01 дүгээр сарын 14-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд баталсан.

Байгууллагын даргын 2019 оны А/461 дүгээр тушаалаар төрийн жинхэнэ албан хаагчийн 2019 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх “Үнэлгээний баг” байгуулж, 01 дүгээр сарын 21-ээс 22-ны өдрүүдэд төрийн захиргааны 157 албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэллээ.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу төрийн үйлчилгээний 88 албан хаагчийн төрийн албанд ажилласан жилийг тогтоож, болзол хангасан 85 албан хаагчид таваас 25 хүртэл хувийн нэмэгдлийг байгууллагын даргын тушаалаар, Засгийн газрын 2019 оны 472 дугаар “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг үндэслэн байгууллагын төвийн газар, хэлтсийн 95, орон нутаг дахь газар, хэлтсийн 156 албан хаагчийн албан тушаалын цалинг шинэчлэн тогтоож байгууллагын даргын тушаалаар тус тус баталсан.

Байгууллагын 2020 оны сургалтын төлөвлөгөө, байгууллагын даргын тушаалын дагуу “Удирдах албан тушаалтан, албан хаагчдын цугларалт, сургалтыг зохион байгуулсан. Цугларалт, сургалтад байгууллагын удирдлага болон төв, орон нутаг дахь газар, хэлтсийн 14 удирдах албан тушаалтан, 48 албан хаагч хамрагдсан. Мөн албан хаагчдын мэдээллийн цагаар “Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлт”, “Гүйцэтгэлийн төлөвлөгөө үнэлэх аргачлал”, “ХАСХОМ-ийг хэрхэн мэдүүлэх”, “Төрийн албаны шинэтгэл” сэдвээр тус тус сургалт, мэдээллийг зохион байгуулж давхардсан тоогоор байгууллагын төвийн 104, онлайн хэлбэрээр орон нутаг дахь газар, хэлтсийн 78 албан хаагч тус тус хамрагдлаа.

Байгууллагын 2020 оны сургалтын төлөвлөгөө, байгууллагын даргын тушаалын дагуу хяналтын улсын байцаагчийн эрх олгох ээлжит сургалт эхлээд байна.

Байгууллагын хэрэгжүүлж буй чиг үүрэг, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор “MNB World” сувагтай хамтран “Гадаадын иргэн ба ёс заншил” сэдвийн хүрээнд “Монголчуудын цагаан сар” 40 минутын танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэж ажиллав.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан гадаадын иргэдийн хил нэвтрэлттэй холбоотой асуудлаар Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн “Монголын Мэдээ” сувгийн “Өдрийн онцлох зочин” 20 минутын шууд ярилцлагад байгууллагын дарга оролцсон. Мөн шашны байгууллагуудын талаар Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагчаас тодруулга ярилцлага бэлтгэн, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд авлигын хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий зурагт хуудас, 10 секундийн видео бичлэгийг англи, монгол хэл дээр бэлтгэж олон нийтэд хүргэв.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 160 өргөдөл, гурван гомдол ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 148 өргөдөл, гурван гомдол шийдвэрлэгдэж, 12 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байна. Хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй.

Байгууллагын даргын 2018 оны А/107 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан зохион байгуулалтын нэгжээс байгууллагын архивт баримт хүлээн авах хуваарийн дагуу 2019 онд үүсэж бий болсон нийт 1510 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, байгууллагын архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлтийг хийлээ.

Байгууллагын гар бөмбөг, сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг төв, орон нутаг дахь нийт газар, хэлтсийн албан хаагчдын дунд зохион байгуулж спортын шилдгүүдээ тодруулан, шилжин явах цомын эзэн багаа тодруулсан.

“Цасны хачир” ХХК-тай №0044 дугаар бүхий хамтран ажиллах гэрээг байгуулан байгууллагын төвийн А, Б байранд ариутгал, халдваргүйжүүлэлтийг албаны өрөө тасалгаа, цайны газар, спорт заал, авто граж, хонгилуудад хоёр удаа хийсэн. Мөн “COVID 19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахад зориулж нэг удаагийн амны хаалт 2925 ширхэг, даавуун амны хаалт 2103 ширхэг, шүүлтүүртэй амны хаалт 380 ширхэг, хамгаалах хувцас 122 ширхэг, нүүрний пластик хамгаалалт 100 ширхэг, нэг удаагийн малгай 153 ширхэг, нэг удаагийн бээлий 1150 ширхэг, хамгаалах нүдний шил 20 ширхэг, гар ариутгалын халдваргүйжүүлэгч бодис 175 литр, эмнэлгийн спирт 15 литр, ариутгалын бодис 258 хайрцаг, халуун хэмжигч 20 ширхгийг хүлээн авч хуваарийн дагуу орон нутаг дахь газар, хэлтэст хүргүүлсэн.

“COVID 19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор тус байгууллагад нэвтрэх иргэдийг угтах, халууныг хэмжих, бүртгэл хийх албан хаагчдын 03, 04 дүгээр сард ажиллах өдрийн хуваарийг баталлаа. Мөн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал цуцлагдах хүртэл Гадаадын иргэн, харьяатын газрын “COVID 19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталсан. Гадаадын иргэн, харьяатын газрын “COVID 19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар байгууллагын Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб нэг удаа хуралдав.

“Заавар батлах тухай” Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын дагуу тус байгууллагын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Улсын онцгой комиссын шуурхай штабт халдвар хамгааллын хэрэгслийн судалгааг гаргаж [uok.shtab@nema.gov.mn](mailto:uok.shtab@nema.gov.mn) цахим хаягаар хүргүүлэв.

Байгууллагын эмчээс 03 дугаар сарын 09-ний өдөр байгууллагын төв байрны бүх өрөө, тасалгаагаар явж албан хаагчдад “COVID 19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт хичээлийг зааж, зөвлөмжийг орон нутаг дахь нэгж нэг бүрд хүргэсэн.

Мөн байгууллагаар үйлчлүүлсэн болон нэвтэрсэн иргэдийг бүртгэж, халууныг хэмжин шаардлагатай тохиолдолд асуумж авч, зөвлөгөө өгөн ажиллаж 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1666 иргэд нэвтэрч бүртгүүлснээс биеийн дундаж температур 36.6°C байв.

Орон нутаг дахь газар, хэлтэст “COVID 19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх 14 цуврал зурагт сануулга зөвлөмжийг хүргүүлсэн.



## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Санхүү, эдийн засгийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны тухай” 2002 оны 142/124 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болгуулахаар хамтарсан тушаалын төслийг боловсруулж, холбогдох материалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлснийг хоёр сайдын 2020 оны 34, А/29 дүгээр тушаалаар хүчингүй болгож ирүүлсэн.

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөлд тус тус байгууллагын зүгээс тусгах санал, Монгол Улсын дипломат, албан паспорт олгох, эзэмших, хадгалах журмын төсөлд тус байгууллагын зүгээс тусгах саналыг албан бичгээр, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр хэлэлцэхтэй холбогдуулан хуулийн төслийг дахин хэлэлцэж, саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим шуудангаар тус тус хүргүүлэв.

Байгууллагын үйл ажиллагаанд хамаарах хэрэглэгдэхээ больсон Засгийн газрын 2001 оны 71, 2011 оны 04 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулах Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан хүргэлээ.

Байгууллагын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий 176 албан хаагчийн /гаргах шаардлагатай 179/ нэрсийн жагсаалтыг Авлигатай тэмцэх газарт албан бичгээр хүргүүлсэн ба [www.meduuleg.iaac.mn](http://www.meduuleg.iaac.mn) цахим хуудаст хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий 179 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар хянан, баталгааны маягыг хүлээн авч баталгаажуулсан.

Түүнчлэн 22 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлж, шинээр томилогдсон нэг, шилжин томилогдсон гурван албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч хянан баталгаажуулав.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Зөвлөмжийн дагуу баталсан Гадаадын иргэн, харьяатын газраас Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр 2019 онд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, Авлигатай тэмцэх газраас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, тус байгууллагаас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 2019 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг тодорхойлон Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох баримтыг хавсарган тус тус албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.

Түүнчлэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2020 онд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан баталлаа.

Бүгд Найрамдах Тажикистан Улсын Душанбе хот дахь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Хилийн менежментийн коллежид зохион байгуулагдах “Хилийн менежмент аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудын ахлах, дунд түвшний албан хаагчдын 26 дахь удаагийн сургалтад оролцох албан хаагчийн бэлтгэл ажлыг ханган, сургалтад хамрууллаа.



Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын Азийн түнш орон Тайландын Вант Улсад 2020 оны 06 дугаар сард зохион байгуулагдах “Цагаачдын хөдөлмөр эрхлэлтийн менежментийг сайжруулах шилдэг туршлага” сэдэвт сургалт, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Энэтхэгийн техник, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд тус улсад зохион байгуулагдах “Кибер аюулгүй байдлын тусгай хөтөлбөр” сэдэвт сургалтад холбогдох албан хаагчдыг оролцуулах бэлтгэлийг хангасан.

Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яамны Консул Ноён Кил Кан Мугыг Гадаадын иргэн, харьяатын газрын хүндэтгэлийн арга хэмжээнд, Гадаадын иргэн, харьяатын газар болон Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз хамтран зохион байгуулсан “Монгол Цагаан сар” нэвтрүүлэгт Америкийн Нэгдсэн Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын найман төлөөлөгчийг урьж оролцуулах ажлыг тус тус амжилттай зохион байгууллаа.

Байгууллагын дарга Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайд И Ёо Хунтай Бүгд Найрамдах Солонгос Улсын Элчин сайдын яамны байранд уулзалт хийн цаашдын хамтын ажиллагааны талаар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин Сайд Цай Вэнь Руйг байгууллагадаа хүлээн авч уулзан хоёр байгууллагын цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын яамны Консул Кил Кан Муг-ийг байгууллагадаа хүлээн авч уулзав. Тус уулзалтаар Бүгд Найрамдах Солонгос Улсын визийн журамд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл аван, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

### 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Төрийн мэдээллийн “ХУР” системээс тоон гарын үсгээр баталгаажуулан мэдээлэл авах модулийг хөгжүүлэн “ХУР ПРОКСИ” программд холбож ажиллагаанд оруулав. Тус байгууллага “Тридум Кей” ХХК-аас 60 ширхэг тоон гарын үсгийн e-Token төхөөрөмжийг худалдан авсан бөгөөд холбогдох тохиргоог хийлгүүлэхээр төхөөрөмжүүдийг Үндэсний дата төвд хүргүүлсэн.

Мөн шинээр Виз, зөвшөөрөл, харьяатын газарт ашиглагдах төрийн бус байгууллагын бүртгэлийн программ хангамжийг шинээр хийж ажиллагаанд оруулж, Монгол Улсын харьяат болох хүсэлтийг бүртгэх программ хангамжийн хөгжүүлэлтийг хийж байна.

### 2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2020 онд 7.7 тэрбум төгрөг батлагдсан. Нэгдүгээр улиралд 1 тэрбум 794.1 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 1 тэрбум 279.6 сая төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу энэ оны нэгдүгээр улирлын байдлаар 480.7 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн

орлого, 195.3 сая төгрөгийн хүү торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэн ажиллалаа.

Орон нутаг дахь газруудаас 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тайлбар, тодруулгын хамт авч нэгтгэн программд орууллаа. Мөн байгууллагын төвийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тайлбар, тодруулгын Үндэсний аудитын газарт албан бичгээр хүргүүлсэн.

Байгууллагын даргын 2019 оны А/459 дүгээр тушаалын дагуу төв болон орон нутаг дахь газар, хэлтсийн эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллого хийлээ.

2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Хууль, зүй дотоод хэргийн сайдын 2019 оны А/223 дугаар тушаалаар баталсны дагуу [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст ил тод байршууллаа. Тус төлөвлөгөөний дагуу 2020 оны байгууллагын албан хэрэгцээнд шатахуун нийлүүлэх тендерийг цахимаар зарлаж, шалгаруулсан бөгөөд Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, Мэдээлэл, технологийн лиценз, Гадаадын иргэдийн цахим бүртгэл, Дүрэмт хувцасны тендерийг цахимаар зарлаж, сонгон шалгаруулалт хийлээ.

Байгууллагын төв байрын угтах хэсгийн засварын ажлыг “Зөв хийц” ХХК бүрэн хийж дуусгасан бөгөөд албан хаагчдын дотоод нөөц бололцоог дайчлан өрөө, тасалгаануудад урсгал засварын ажлыг эхлүүлээд байна.

#### 2.5. Хяналт шинжилгээ, дотоод аудитын чиглэлээр:

Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын 2018, 2019 оны харьцуулсан мэдээ, 2019 оны 12 дугаар сар, 2020 оны 01, 02 дугаар сарын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яаманд, байгууллагын 2019 оны танилцуулах тойм мэдээ, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын 2019 оны дөрөвдүгээр улирлын танилцуулах тойм мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд, 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэд болон Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэдийн мэдээ, Монгол Улсын харьяат болсон, иргэний харьяаллаа сэргээн тогтоосон, харьяатаас гарсан иргэдийн мэдээг Үндэсний статистикийн хороонд, байгууллагын 2019 оны танилцуулах тойм мэдээ болон 2019 оны 12 дугаар сар, 2020 оны 01, 02 дугаар сарын үйл ажиллагааны мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын Ажлын албанд тус тус албан бичгээр хүргүүлсэн.

Байгууллагын үйл ажиллагааны 2001-2019 оны тоон мэдээллийг нэгтгэн “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны статистик эмхэтгэл”-ийн эхийг боловсруулан бэлтгэлээ.

Байгууллагын 2019 оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хэрэгжилт, байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар

байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт, байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ хийн үнэлгээ өгч, Даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлснээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн яаманд байгууллагын үйл ажиллагааны 2019 оны дотоод аудитын хураангуй болон дэлгэрэнгүй тайлан, 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан албан бичгээр, Үндэсний аудитын газрын 2018 оны дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг холбогдох газруудаас авч нэгтгэн, хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг гарган албан бичгээр тус тус хүргүүллээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд төв болон орон нутаг дахь газруудын [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст байршуулсан 2019 оны дөрөвдүгээр улирлын мэдээлэлд байгууллагын даргын баталсан удирдамжийг удирдлага болгон хяналт тавьж ажилласан.

Санхүү, хангалт, үйлчилгээний газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийх байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу харилцах, касс, цалин хөлс болон бусад холбогдох анхан шатны баримтын бүрдэл, төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгах тухай зөвлөмж, хугацаатай үүрэг өгч ажиллалаа.

## 2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

“Хил хяналтын байгууллагын ажлын уялдаа холбоог хангах тухай”, “Хилийн боомтыг шилжүүлэх тухай”, “Агаарын замын боомтын асуудлаар авах арга хэмжээний тухай” Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн зөвлөмж, тогтоолын 2019 оны 12 дугаар сар, 2020 оны 01, 02 дугаар сарын хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүлэв.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу гадаадын 19 улсын 169 иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба зохих бичиг баримтын бүрдэл хангаагүй гадаадын нэг улсын хоёр иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан.

2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналт, мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдсэн нийт 100.001 гадаадын иргэнээс түүврийн аргаар 2000 гадаадын иргэдэд хяналт тавихад овог нэр зөрүүтэй, давхардуулж бүртгэсэн 254, Монгол Улсын хилээр гараагүй хугацаа хэтрүүлсэн 34, төрсөн он, сар, өдөр зөрүүтэй 28, харьяалах улс буруу, хоосон бүртгэсэн 12, оршин суух зөвшөөрлийн хугацаанд нас барсан нэг гадаадын иргэн байсан. Эдгээр 2000 гадаадын иргэнээс 1965 иргэн нь Монголын Улсын хилээр гарсан байх ба 302 гадаадын иргэний овог, нэр, төрсөн, он, сар, өдөр, харьяалах улсыг буруу давхар бүртгэл үүсгэж бүртгэсэн тул дээрх зөрчлүүдийг арилгах зорилгоор холбогдох системд өөрчлөлт, хөгжүүлэлт хийх хэрэгцээ, шаардлага болон 100.001 гадаадын иргэдийн мэдээллийг Хил хамгаалах ерөнхий газар болон Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт тус тус албан бичгээр хүргүүлсэн.

Хөшигийн хөндий дэх “Чингис хаан” олон улсын нисэх буудал ашиглалтад орохтой холбогдуулан Агаарын замын боомт хариуцсан газрын орон тоог нэмүүлэх санал, хүсэлтийг Сангийн сайдад, Баян-Өлгий аймгийн “Өлгий” нисэх буудалд шинээр боомт байгуулж, олон улсын нисэх буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай орон тоо, гарах зардлын тооцооны саналыг Иргэний нисэхийн ерөнхий газарт албан бичгээр тус тус хүргүүллээ.

“Зарлиг гаргах тухай” Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 07/05 дугаар зөвлөмж, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” /Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөн оны 10 дугаар зарлиг, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” Засгийн газрын мөн оны 62 дугаар тогтоол, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын мөн оны 63 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг ханган ажиллах талаар албан хаагчдад мэдээлэл өглөө.

Мөн байгууллагын даргын “Бэлэн байдлын хэсэгчилсэн зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 03 дугаар албан даалгавар, “Шинэ коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгаврыг тус тус боловсруулан батлуулж, орон нутаг дахь газруудад хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

“Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай” Засгийн газрын 2020 оны 39 дүгээр тогтоол, “Хилийн зарим боомтыг түр хаасантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын онцгой комиссын мөн оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг орон нутаг дахь газар, хэлтэст албан бичгээр үүрэг өглөө.

Улсын онцгой комисст энэ оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/437 дугаар албан бичгээр Монгол Улсад оршин сууж буй гадаадын иргэдийн танилцуулгыг хүргүүлж, тэдгээрийн визийн хугацааг хэрхэн сунгах талаарх саналыг хүргүүлэн 03 дугаар сарын 08-ны өдрийн 04 дүгээр тогтоолд тусгууллаа.

“Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн 04 дүгээр тогтоол, “Зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох тухай” Улсын онцгой комиссын мөн оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоол, “Иргэд зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай” Улсын онцгой комиссын мөн оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолын хэрэгжилтэд тухай бүр хяналт тавин ажиллаж байна.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР